

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 08 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 17.30 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 3 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Авлигатай тэмцэх газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмын төслийн тухай	“Авлигатай тэмцэх газрын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын төслийг батлах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Төрийн өмчийн хорооны дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны дэд даргын албан тушаалд Оюуны Эрдэнэбулганыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Сүхбаатарын Батболдыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанг томилсон тус яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн тухай	Энэ асуудлыг БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга шийдвэрээ гаргаад чөлөөлсөн учир хэлэлцэх шаардлагагүй болсон.
5	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын албан тушаалд Жаргалсайханы Зоригтбаатарыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Ө.Одгэрэлийн	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигч Ө.Одгэрэлийн гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай

	гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	асуудлыг Зөвлөлийн дараагийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэхээр хойшлуулав.
7	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын гадаад харилцааны тасгийн даргаар ажиллаж байсан Д.Чинбатын гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>1.Иргэн Дарамбазарын Чинбатын албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүрэг өөрчлөгдөөгүй, хэвээр хадгалагдан үлдсэн, 2009 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр “В” буюу “хангалттай” дүн авсан байхад түүнийг албан тушаал бууруулсан нь Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлд заасныг зөрчсөн байна” гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.Д.Чинбатыг албан тушаалын ангилал, зэрэглэл болон өмнө авч байсан цалин хөлс, нэмэгдлийг бууруулахгүйгээр зохих албан тушаалд томилж, ажиллуулахыг Биеийн тамир, спортын газрын дарга Ч.Наранбаатарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны зарим албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах талаар ирүүлсэн саналын тухай	<p>1.Тэргүүн түшмэлийн зэрэг дэвийн: С.Чинзоригт тэргүүн, Д.Эрдэнэчулуунд дэд, Ц.Шаравдоржид тэргүүн, П.Дамдиндоржид гутгаар, Ц.Ням-Осорт дөтгөөр, Г.Баясгаланд тэргүүн, Д.Насанжаргал, Ц.Нарантунгалаг, Ц.Норовдондог, Д.Одсүрэн, Г.Чиндэгсүрэн, Д.Баяндүүрэн, Б.Энхтөр, Б.Цэнгэл нарт дөтгөөр зэрэг тус тус олгохоор,</p> <p>2.Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн: Т.Бат-Өлзий, Ц.Цолмон, Ч.Нарантуяа, Л.Мөнхцэцэг нарт дэд зэрэг, Р.Цогтбаатарт дөтгөөр, Н.Оюунчимэгт дөтгөөр, С.Ганболдод дөтгөөр, Т.Оюунчимэгт тэргүүн зэрэг, Ж.Нэргүй, Ё.Мөнхбаатар, Д.Мягмарсүрэн, О.Тунгалаг, Ю.Эрдэнэтуяа, Б.Балган, Ц.Жаргалсайхан, Г.Алтан-Оч, Ч.Ариунхур, Ц.Товуусүрэн, А.Туул нарт тус тус дөтгөөр зэрэг, Э.Оюунбилэг, А.Лхагвасүрэн, Д.Энхжаргал, С.Бямбаа нарт дөтгөөр зэрэг, Д.Энхбаатарт гутгаар зэрэг, Б.Баасанд гутгаар зэрэг, Б.Махбал, Д.Наранпүрэв нарт дэд зэрэг, С.Очирбатад дөтгөөр, Д.Мөнхбаатарт дэд зэрэг, Г.Мягмарт дэд зэрэг, Ө.Сувдаад дөтгөөр зэрэг тус тус олгохоор шийдвэрлэж, Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэхээр болов.</p>